

БНХАУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО, ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Б.Нарантунгалаг*

БНХАУ-ын батлан хамгаалахын бодлого, төсөв

БНХАУ нь цэвэр батлан хамгаалахын мөн чанарыг илэрхийлсэн, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний хөгжлийн ашиг сонирхол болон Хятадын бүх ард түмний нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах батлан хамгаалахын бодлого хэрэгжүүлэх байр суурийг баримталдаг гэдгээ албан ёсоор илэрхийлдэг.¹ БНХАУ нь үндэсний аюулгүй байдал болон хөгжлийн ашиг сонирхолтой зохицох хүчирхэг зэвсэгт хүчин, үндэсний батлан хамгаалах зэвсэгт хүчинг бататган бэхжүүлэхийг зорьж байна.

Шинэ зуун эхэлснээр БНХАУ-ын үндэсний батлан хамгаалах бодлого өөрчлөгдөн шинэ үе шатанд гарсан гэж үздэг. Энэхүү бодлогод үндэсний аюулгүй байдал, эв нэгдлийг дэмжих, үндэсний хөгжлийн ашиг сонирхлыг хангах; БНХАУ-ын үндэсний батлан хамгаалах болон зэвсэгт хүчнийг тал бүрээр, зохицол бүхий, тогтвортой хөгжүүлэх; мэдээлэлжүүлсэнээр зэвсэгт хүчний бодит гүйцэтгэлийг сайжруулах; цэргийн батлан хамгаалахын стратегийг хэрэгжүүлэх; өөрийгөө хамгаалах цөмийн стратегийг үргэлжлүүлэх; мөн Хятадын энх тайвнаар хөгжих аюулгүй орчныг хамгаалах гэсэн зүйлс багтжээ.²

БНХАУ нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин болон үндэсний аюулгүй байдлын хэрэгцээ шаардлагын дагуу үндэсний батлан хамгаалах, зэвсэгт хүчинг шинэчлэх үе шат бүхий хөгжлийн стратегийг хэрэгжүүлж байна. Энэхүү стратегийн хүрээг дараах байдлаар тодорхойлж болно.

Үүнд:

1. **БНХАУ-ын үндэсний батлан хамгаалах, зэвсэгт хүчний мэдээлэлжүүлэлтийг сайжруулах:** Үндэсний батлан хамгаалах болон зэвсэгт хүчний шинэчлэлийн нэг зорилго бол мэдээлэлжүүлэлт юм. БНХАУ-ын зэвсэгт хүчний хөгжлийн стратеги, үндэсний батлан хамгаалах, зэвсэгт хүчний стратеги төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэстэй томъёолохын тулд 2010 онд үндсэн суурийг тавьж, 2020 онд автоматжуулалт, мэдээлэлжүүлэлтийн томоохон дэвшлийг хийж, XXI дүгээр зууны дунд үед шинэчлэлтийн зорилгод хүрнэ гэж тодорхойлжээ.

* МУИС, ОУХС-ийн ахлах багш, Ph.D

1. БНХАУ-ын үндэсний батлан хамгаалах яамны сайт: <http://www.mod.gov.cn>

2. <http://www.mod.gov.cn>

2. Эдийн засгийн хөгжил ба БНХАУ-ын үндэсний батлан хамгаалахын байгуулалыг сайтар төлөвлөх: Үндэсний батлан хамгаалах, эдийн засгийн хөгжлийг зохистой байлгах зарчимд тулгуурлан зэвсэгт хүчнийг хүчирхэгжүүлэх болон улс орныг баян чинээлэг болгох хоёр асуудлын хоорондох тэнцвэрийг барихад чиглүүлж үндэсний нөөцөө оновчтой ашиглах төлөвлөгөөтэй байна.

3. БНХАУ-ын үндэсний батлан хамгаалах ба зэвсэгт хүчний шинэчлэлийг гүнзгийрүүлэх: Хятад улс зэвсэгт хүчний бодлого, бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн зохицуулалт хийж байна. БНХАУ батлан хамгаалахын шинэчлэлийн системийг хурдан, үр ашигтай, итгэл хүлээсэн, сайн бүтэцтэй, төвлөрсөн нэгдсэн системтэй болгон сайжруулахыг чармайж байна.

4. Үсрэлттэй хөгжих замыг сонгох: Хятад улс автоматжуулалт болон мэдээлэлжүүлэлтийн хөгжлийг нэгдмэл байдлаар бүтээж байна. Шинжлэх ухаан, технологийн талаас нь зэвсэгт хүчнийг хүчирхэгжүүлж, шинэ өндөр технологи бүхий байлдааны зэвсэг, тоног төхөөрөмжийг хөгжүүлэхээр ажиллаж байна. Мөн орчин үеийн ложистик хангамжийн системийг бүрдүүлэх, мэдээлэлжүүлсэн нөхцөлд цэргийн сургалтыг удирдах, авьяаслаг хүмүүсийг сургаснаар байлдах чадвар бүрэлдэн тогтох хэв маягийг өөрчлөх стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.

БНХАУ нь стратегийн хувьд зөвхөн дайсныг эхэлж довтолсон нөхцөлд л өөрийгөө бүх талаар хамгаална гэсэн батлан хамгаалах үйл ажиллагааны зарчмыг баримталдаг. БНХАУ шинэ үеийн батлан хамгаалахын байлдааны стратегийн зарчмаа томъёолохдоо үндэсний хөгжлийн стратеги, үндэсний батлан хамгаалахын хэрэгцээ шаардлага болон цэргийн зэвсэгт хүчний хөгжлийн шинэ хандлага бүрэлдүүлэхэд үндэслэжээ. Энэхүү зарчим нь дайн самууныг зогсоох; зэвсэгт хүчний олон талт зорилгыг хэрэгжүүлэх, аюулгүй байдалд учруулж буй эрсдэлээс хамгаалах зэвсэгт хүчний чадавхийг сайжруулах; дайны стратегийн талаарх ард түмний ойлголтыг сайжруулахад чиглэсэн байна. Мөн Хятадын чөлөөлөх армийн хөгжлийг үндэсний бүтээн байгуулалт, дотоодын нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих, арми болон ард түмэн, засгийн газар хоорондын нэгдлийг бэхжүүлэхэд чиглэжээ.

БНХАУ-ын батлан хамгаалахад зарцуулж буй төсвийн талаар авч үзэхэд, 1998-2007 оны хооронд БНХАУ-ын батлан хамгаалахын салбарын төсөв жилд дунджаар 15.9 хувиар өссөн хэмээн АНУ-ын Үндэсний Стратеги Судлалын хүрээлэнгээс мэдээлсэн байна.³

2012 оны 3 сард БНХАУ тухайн онд батлан хамгаалахын салбарт зарцуулах төсвийг 670 тэрбум юан буюу 106.4 тэрбум ам.долларт хүргэх болсон талаар Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын төлөөлөгч Ли Жао Син мэдээлсэн.⁴ Энэхүү 2012 оны батлан хамгаалах салбарт

3. <http://inssblog.wordpress.com/2012/03/26/chinas-2012-defense-budget-steady-as-she-goes/>

4. <http://inssblog.wordpress.com/2012/03/26/chinas-2012-defense-budget-steady-as-she-goes/>

зарцуулах төсөв нь ДНБ-ний 1.5 хувь, засгийн газрын зардлын 6 хувийг эзэлж байна. БНХАУ нь батлан хамгаалах салбарын төсвийг сүүлийн 2 жилд дараалан хоёр оронтой тоогоор буюу 2011 онд өмнөх оныхоос 12,7 хувиар, 2012 онд 2011 оныхоос 11.2 хувиар өсгөсөн үзүүлэлттэй байна. Эндээс сүүлийн жилүүдэд батлан хамгаалахын зардал ДНБ-ийн өсөлтийн хурдаас их байгааг харж болно. Тухайлбал БНХАУ 2012 онд ДНБ-ийг 7.5 хувиар, харин батлан хамгаалахын төсвийг 11.2 хувиар өсгөхөөр зорьсон байна. Батлан хамгаалахад зарцуулж буй төсвийн энэхүү өсөлтийг Ли Жао Син Хятадын “энх тайвнаар хөгжих” болон хамгаалахад чиглэсэн батлан хамгаалахын бодлоготой нийцүүлэн нэмэгдүүлсэн бөгөөд Хятадын батлан хамгаалахын зардал нь бусад том гүрэн улсуудтай харьцуулахад харьцангуй бага байгаа хэмээн тайлбарлажээ. Ийм нэмэлт ачааллыг эдийн засгийн өсөлт нь дааж чадах учраас Хятад улс батлан хамгаалахын зардлыг нэмэгдүүлж байгаа гэж тэр нэмж хэлсэн гэж Франс пресс агентлаг мэдээлжээ.⁵

Доорх хүснэгтээс 2000-2012 оны БНХАУ-ын батлан хамгаалахын салбарын төсвийн үзүүлэлтийг харж болно.

Хүснэгт 1

БНХАУ-ын батлан хамгаалах салбарт зарцуулж буй төсөв

Он	БНХАУ-ын батлан хамгаалахын төсөв		Он	БНХАУ-ын батлан хамгаалахын төсөв		Он	БНХАУ-ын батлан хамгаалахын төсөв	
	тэрбум.юан	тэрбум ам.доллар		тэрбум.юан	тэрбум ам.доллар		тэрбум.юан	тэрбум ам.доллар
1989	25	6.7	1997	81	9.8	2005	248	29.9
1990	29	6.1	1998	94	11.3	2006	280	35.3
1991	33	6.2	1999	108	13	2007	351	45
1992	38	6.9	2000	121	14.6	2008	418	57.2
1993	43	7.4	2001	141	17	2009	481	70.3
1994	55	6.6	2002	166	20	2010	532	77.9
1995	64	7.6	2003	185	22.4	2011	601	91.5
1996	72	8.6	2004	207	25	2012	670	106.4

Эх үүсвэр: <http://www.globalsecurity.org/military/world/china/budget-future.htm>

5. http://mongolian.ru/2012_03_04/67457737/

БНХАУ-ын батлан хамгаалахын салбарын төсвийн талаарх гадаад судлаачдын байр суурь:

Хятадын батлан хамгаалахын төсвийн энэхүү өсөлт нь Вашингтоноос цэрэг стратегийн ашиг сонирхолын үндсэн бүс гэж зарлаад байгаа Ази Номхон далайн бүс нутаг дахь АНУ-ын идэвхижил өсөн нэмэгдэж байгаатай холбоотой гэж олон шинжээчид үзэж байна. Ази номхон далайн бүс нутагт хүйтэн дайны үе эргэж ирж байна гэж хэлж болохоор байна. Өмнө нь Ази тив болон Номхон далайд ЗХУ, АНУ өрсөлддөг байсан бол одоо АНУ, БНХАУ хоёр тэргүүлэхийн төлөө тэмцэж байна хэмээн Оросын дуу хоолой радио мэдээлжээ.⁶

Хятадын чөлөөлөх армийн хүчин чадлыг нэмэгдүүлэхийг Бээжин урьдын адил тэргүүлэх чиглэл гэж үзсээр байна. Тэнгисийн цэргийн флот болон нисэх хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх нь Хятадын зэвсэгт хүчнийг шинэчлэх үндсэн чиглэл болж байна гэж “Үндэсний батлан хамгаалалт” оросын сэтгүүлийн ерөнхий редактор Игорь Коротченко бичсэн байна.⁷

БНХАУ-ын батлан хамгаалахын төсвийн өсөлтийн талаар АНУ-ын судлаачид дараах байр суурьтай байна. Ази дахь АНУ болон Хятадын цэргийн тэнцвэрийн байдалтай холбоотойгоор БНХАУ-ын батлан хамгаалахын төсөв нэмэгдэж байна. Хятадын өсч буй эдийн засаг нь засгийн газраас зэвсэгт хүчний шинэчлэлийг хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлж байна. Хятад улс АНУ-ыг гүйцэж цэргийн зардлаараа дэлхийд тэргүүлэх сонирхолтой. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи 20 гаруй жилийн хугацаанд Хятад улсын батлан хамгаалахын зарцуулалт жилд дунджаар ойролцоогоор 10 хувиар өсч байсан. Хэрэв энэхүү өсөлт хэвээр үргэлжилбэл 2033 он гэхэд өнөөгийн АНУ-ын батлан хамгаалахын зарцуулалтыг давж гарна.⁸ Ерөнхийдөө төсвийг тайлагнахдаа бодит зарцуулалтыг бууруулж, дарсан гэдэгтэй америк судлаачдын ихэнхи нь санал нийлж байна хэмээн америкийн талын мэдээлэлд илэрхийлсэн байна. Тухайлбал, Хятадын засгийн газрын албан ёсны батлан хамгаалахын төсөвт хагас цэрэгжүүлсэн хүчин, зэвсэгт хүчний хөгжлийн судалгаа, гадаад хуримтлал, стратегийн зэвсэгт хүчинд зарцуулсан зардал зэрэг төсвийн чухал хэсгүүдийг оруулаагүй байна хэмээжээ. Худалдан авах чадварын паритетээр тооцоход БНХАУ-ын батлан хамгаалахын зардал 2018 онд АНУ-ын батлан хамгаалахын зардлыг 400 тэрбум.ам.доллараар давж, 2025 онд АНУ-нхаас 2 дахин их болно⁹ хэмээн америкийн зарим судлаачид үзэж байна.

6. http://mongolian.ru.ru/2012_03_04/67457737/

7. http://mongolian.ru.ru/2012_03_04/67457737/

8. <http://www.globalsecurity.org/military/world/china/budget-future.htm>

9. <http://www.globalsecurity.org/military/world/china/budget-future.htm>

БНХАУ-ын батлан хамгаалахын салбарын төсвийн талаарх Хятадын талын байр суурь:

Хятадын сонинд 2012 оны 4 сард дараах мэдээллийг нийтэлсэн байна. Хятадын хууль тогтоох дээд байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллага жил бүр Хятадын батлан хамгаалахын төсвийг мэдээлдэг, харин барууны хэвлэл мэдээлэл арилжааны зориулалттай гарчиг бүхий “Хятадын аюул занал”-ын тухай мэдээлэл нийтэлсээр байна. Ихэнх улс орнууд батлан хамгаалахын төсөвтэй байдаг бөгөөд бусад улс оронтой харьцуулахад Хятадын батлан хамгаалахын төсөв нь хамгийн том нь ч биш, хамгийн хурдан өсөлттэй нь ч биш. Хэмжээний хувьд авч үзвээс 2012-2013 оны АНУ-ын батлан хамгаалахын төсөв 662 тэрбум ам.долларт, харин Хятадынх 106 тэрбум ам.долларт хүрсэн байна. Өсөлтийн хувьд харьцуулваас 2012-2013 оны хооронд Энэтхэгийн батлан хамгаалахын төсөв өмнөх оныхоос 17 хувиар илүү байхад Хятадынх 11.2 хувиар өссөн байна. Яагаад цэргийн аюул занал учруулж байна хэмээн АНУ, Энэтхэгийг чичлэхгүй байгаа юм бэ? Хятадын батлан хамгаалахын салбарт зарцуулж буй мөнгө бүр иргэн, нутаг дэвсгэрээ хамгаалах болон энх тайвныг хамгаалахад туслахад зориулагддаг хэмээн тэд мэдээлжээ.¹⁰ 2011 онд БНХАУ-ын нэг иргэнийг хамгаалахад оногдох зардал 75 ам.доллар, газар нутгийн нэг км.кв бүрт оногдох хамгаалалтын зардал 9.72 ам.доллар байсан. Харин АНУ-ын хувьд нэг иргэнийг хамгаалахад оногдох зардал 2201 ам.доллар, газар нутгийн нэг км.кв бүрт оногдох хамгаалалтын зардал 75.3 ам.доллар зарцуулсан. Эндээс аль улс нь үнэхээр аюул заналхийлэл илэрхийлж байгааг харахад хэцүү биш байна хэмээн тэд мэдэгджээ. Өөрийгөө хамгаалахад зориулах Хятадын батлан хамгаалахын төсвийн эрэлт нэмэгдэж байна хэмээн зарим нь тайлбарладаг. Гэхдээ Хятад улс хэзээ ч бусад орныг тагнан судлах ажил болон бусад орны ойр орчимд цэргийн сургуулилт хийгээгүй. Хятад улс бусад улс орон болон бүс нутгийн нутаг дэвсгэрээс нэг ямхыг ч булаан эзлээгүйг санах хэрэгтэй. Харин эсрэгээрээ арлууд болон түүн дээрх нөөцийг булаан эзлэх гэж байгаа бусад улсууд байна. БНХАУ нь өөрийн орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгалахын төлөө батлан хамгаалах салбарт мөнгө зарцуулж буйгаа зөвтгөж байгаагаа тэд мөн илэрхийлжээ.

Мөн олон улсын нийгэмлэгүүдийн зүгээс БНХАУ-ыг илүү их глобал үүрэг хариуцлага хүлээх болсоныг тэмдэглэж байна. Энэ нь энэхүү үүргийг биелүүлэхийн тулд цэргийн хангалттай зардалтай байх хэрэгцээтэйг илэрхийлж байна. Мөн түүнчлэн цэргийн албан хаагчдын цалинг инфляцийн түвшинтэй уялдуулах, аюул гамшигаас аврах армийн чадварыг тасралтгүй нэмэгдүүлэх шаардлагатай байна. Харамсалтай нь цэргийн төсвийн зарцуулалтаа яаж ч ил тод байлгасан барууныхан

10. http://www.chinadaily.com.cn/cndy/2012-04/09/content_15000905.htm

үргэлж нууж байгаа зүйлээ ил гаргахыг шаардаж, биднийг төсвийн ил тод байдлыг хадгалахыг хэрхэн чармайж байгааг хамаарч үзэхгүй байна. Өмнөх санхүүгийн жилд Хятадын батлан хамгаалахын зарцуулалт 96.5 тэрбум ам.доллар байсан. Харин Хятадын зэвсэгт хүчний энэ үнэлгээг АНУ 160 тэрбум ам.доллар хэмээн тооцож гаргасан. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Хятадын зэвсэгт хүчний зардлын жилийн өсөлт 18.6 хувиас өндөр байсан хэмээн барууны зарим эрдэм шинжилгээний байгууллага дурддаг. Гэвч энэ хугацаанд гагцхүү 2009 онд Хятадын зэвсэгт хүчний зардал 18 хувиас илүү гарсан байсан.¹¹

2007 онд БНХАУ “Зэвсэгт Хүчний Зардлаа Тайлагнах АНУ-ын Стандартчилсан Гэрээ”-нд нэгдсэнээр жил бүр зэвсэгт хүчний зардлын задаргааг АНУ-д мэдүүлсээр иржээ. Мөн түүнчлэн жилийн зэвсэгт хүчний төсвийг Төрийн Төсвийн Хууль болон Үндэсний Батлан Хамгаалахын Хуульд нийцүүлэн эмхэтгэн зохион байгуулдаг. БНХАУ нь Зэвсэгт хүчний зардлын зарцуулалтыг аудитын шалгалтаар хянуулж, олон улсын нийгэмлэгт тайлагнахаар 2 жил тутамд батлан хамгаалахын талаар засгийн газрын илтгэлийг хэвлэн гаргадаг. Үнэндээ Хятад бол аюултай хэмээн зарлах цөөн орон байна. Учир нь тэд бүгд өөрсдийн хөгжлийг хурдасгахын тулд хуурамчаар дайсагнах хэрэгцээтэй байдаг. Иймд Хятад улс өөрийгөө ашиг хонжооны төлөө бус гэдгийг батлахын зэрэгцээ баталгааг үл харгалзан цэргийн аюул заналтай гэсэн нэр хоч зүүлгэхийг тэвчих ёстой хэмээн Хятадын хэвлэлд өгүүлжээ.¹² Мөн батлан хамгаалах салбараа бэхжүүлэх явдал нь тусгаар тогтносон улсын үүрэг бөгөөд ямар нэгэн улсын дуртай, дургүйд тохируулах шаардлагагүй хэмээн Хятадын тал үзэж байгаагаар илэрхийлжээ.

1. БНХАУ-ын зэвсэгт хүчний олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаа

БНХАУ нь энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг үндэслэн бүх улс орнуудтай аюулгүй байдлыг хамгаалахад хамтран ажиллах, улс төрийн харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх, найрсаг харилцааг хөгжүүлэхээр чармайж байгаагаар илэрхийлсээр ирсэн.

БНХАУ-ын засгийн газар Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд олон талт хамтын ажиллагааг идэвхитэй гүнзгийрүүлэн хөгжүүлж байна. 2007 оны 4 сард болсон Бишкекийн дээд хэмжээний уулзалт дээр Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнууд урт хугацаанд сайн хөршийн харилцаа, найрамдал, хамтын ажиллагаатай байх гэрээ байгуулсан нь харилцан итгэлцэл шинэ үе шатанд гарах, аюулгүй байдлын хамтын ажиллагааны хууль, улс төрийн үндэслэл болж өгсөн. Мөн 2007-2009 оны хооронд гишүүн орнууд цэргийн нэгдсэн сургуулилт зохион байгуулах гэрээ, Батлан хамгаалах яамны хамтын ажиллагааны

11. http://www.chinadaily.com.cn/cndy/2012-04/09/content_15000905.htm

12. http://www.chinadaily.com.cn/cndy/2012-04/09/content_15000905.htm

гэрээ, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын зэр зэвсэг, тэсрэх бодис, байлдааны хэрэгсэл хууль бусаар арилжихтай тэмцэх талаар хамтран ажиллах засгийн газрын гэрээнд гарын үсэг зуржээ.¹³ Үүний зэрэгцээ мэргэжилтэнгүүдийн терроризмыг эсэргүүцэх сургалтын гэрээ гэх мэт хуулийн баримт бичгүүдийг баталж, олон улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсанаар мэдээллийн аюулгүй байдал гэх мэт шинэ талбарт хамтран ажиллах эхлэл тавьсан. Гишүүн орнуудын ерөнхий прокурор, дээд шүүхийн дарга, батлан хамгаалах яамны сайд, аюулгүй байдлын агентлаг болон хууль сахиулах байгууллагын удирдлагууд тогтмол уулзалт зохион байгуулж, шүүх, батлан хамгаалах, хууль сахиулах, аюулгүй байдал болон бусад талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлж байна.

БНХАУ нь АСЕАН-ны орнуудын бүс нутгийн чуулганд томоохон ач холбогдол өгдөг. 2007 оны 4 сард болсон АСЕАН-ны орнуудын бүс нутгийн чуулганы сайд нарын уулзалтанд бүс нутгийн амжилт ололт, сайн сайхан байдал, энх тайван, хөгжлийн хэрэгцээ шаардлага, хууль дүрэмтэй холбогдуулан Ази Номхон далайн бүс нутгийн олон талт болон нийтлэг эрх ашигт тулгуурласан аюулгүй байдлын шинэ ойлголт бий болж буйг БНХАУ онцлон тэмдэглэсэн. 2007-2009 оны хооронд АСЕАН-ын орнуудын бүс нутгийн чуулганы хүрээнд БНХАУ хар тамхийг шалгах семинар, далайн аюулгүй байдлыг хянах талаар дугуй ширээний ярилцлагыг Индонез, Тайландтай тус тусад нь хамтран зохион байгуулсан. БНХАУ байгалийн гамшиг тохиолдоход туслах, хамтран ажиллах тухай ерөнхий зарчим, удирдамжийг төлөвлөсөн нь 14 дэхь удаагийн АСЕАН-ны орнуудын бүс нутгийн чуулганы сайд нарын уулзалтаар дэмжигдсэн.

БНХАУ-АСЕАН болон АСЕАН+Гурав (Хятад, Япон, Солонгос) орнуудын аюулгүй байдлын уламжлалт бус салбар дахь хамтын ажиллагаа гүнзгийрч байна. 2007 оны 1 сард БНХАУ- АСЕАН -ны орнуудын дээд хэмжээний уулзалт, 2007 оны 11 сард АСЕАН +Гурвын дээд хэмжээний уулзалт болж уламжлалт бус аюул заналын эсрэг явуулах хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх санал дэвшүүлж, цэргийн солилцоо, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны чухлыг онцлон тэмдэглэжээ.

БНХАУ нь бусад улс орнуудтай хоёр талын болон олон талт цэргийн нэгдсэн сургуулилтыг зохион байгуулж байна. 2002 оны 10 сард терроризмыг эсэргүүцэх Хятад-Киргизийн нэгдсэн сургуулилтыг эрхлэн явуулсан нь Хятад болон гадаадын зэвсэгт хүчний оролцсон анхны нэгдсэн сургуулилт болсон юм. Энэ үеэс эхлэн БНХАУ-ын Ардын Чөлөөлөх Арми “нээлттэй цэргийн дасгал сургуулилт”-нд оролцох болсон. 2002 оноос хойш Ардын Чөлөөлөх Арми нь 5 тивийн 30 гаруй улс оронтой 60 нэгдсэн сургалт, сургуулилтыг хийжээ.¹⁴ Ойролцоогоор эдгээр сургуулилтуудын

13. <http://www.mod.gov.cn>

14. <http://www.mod.gov.cn>

50 гаруй хувьд нь голлох үүргийг гүйцэтгэсэн байна. Ардын Чөлөөлөх Армийн тэнгисийн цэргийн болон агаарын нисэх хүчний нэгдсэн сургалт, сургуулилтанд оролцох оролцоо өсч байна.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд терроризмын эсрэг, гамшигаас аврах гэх мэт нэгдсэн дасгал сургуулилт өсч байна. Гадаадын зэвсэгт хүчинтэй олон салбарт, урт хугацаанд нягт харилцаатай байснаар Хятадын зэвсэгт хүчин өөрийн чадавхийг нэмэгдүүлсээр байна. 2007 оноос хойш 20 гаруй нэгдсэн сургалт, сургуулилтыг зохион байгуулжээ.

2007 оны 4 сард Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд Хятад, Орос, Казакстан, Киргизстан, Тажикстан, болон Узбекистан улсууд хэт даврагсад, салан тусгаарлагчид, терроризмыг эсэргүүцэхэд чиглэсэн цэргийн нэгдсэн сургуулилтыг Хятадын Шинжаан Уйгурын өөртөө засах бүсд болон ОХУ-ын Челябинскт зохион байгуулсан. Энэ нь Хятадын чөлөөлөх армийн хувьд анх удаа БНХАУ-ын нутаг дэвсгэрээс гадна хийсэн газрын болон агаарын нэгдсэн чухал сургуулилт болсон юм.

2007, 2008 оны 7 сард Тайландтай хамтран 2 орны армийн онцгой байлдааны үйл ажиллагааг багтаасан терроризмыг эсэргүүцэх нэгдсэн сургуулилтыг Хятадын Гуанжоү, Тайландын Чиан Майд зохион байгуулжээ.

2007, 2008 оны 12 сард Хятад, Энэтхэгийн арми терроризмыг эсэргүүцэх нэгдсэн сургуулилтыг Хятадын Күнмин, Энэтхэгийн Белгаумд явуулсан байна.

2007-2009 оны хооронд Хятадын тэнгисийн цэргийн хүчин ОХУ, Их Британи, Франц, АНУ, Пакистан, Энэтхэг, Өмнөд Африк гэх мэт 14 улсын тэнгисийн цэргийн хүчинтэй 2 талын, тэнгисийн цэргийн нэгдсэн сургуулилтыг хийжээ. БНХАУ мөн тодорхой зорилгоор, холбогдох улс орнуудтай олон талт, тэнгисийн цэргийн нэгдсэн сургуулилтыг зохион байгуулсаар иржээ.

2007 оны 3 сард 7 оронтой “Энх тайван 2007” гэсэн тэнгисийн цэргийн нэгдсэн сургуулилтыг Арабын тэнгист явуулжээ.

Баруун номхон далайн тэнгисийн цэргийн бага хурлын хүрээнд 2007 оны 5 сард Сингапурыг багтаасан бусад 8 оронтой олон талт, тэнгисийн цэргийн нэгдсэн сургуулилтыг зохион байгуулжээ. Тухайн оны 10 сард БНХАУ, Австрали, Шинэ Зеландтай хамтран Тасманы тэнгист тэнгисийн цэргийн судлах ба аврах нэгдсэн сургуулилтыг хийсэн байна.

БНХАУ-ын Батлан Хамгаалах Яамны гадаад хэрэг эрхлэх газрын дарга Чизен Ли Хуа¹⁵ Хятадын цэргийн гадаад харилцааг тоймлон дараах байдлаар тодорхойлж болно хэмээжээ. Үүнд:

1. Том гүрнүүдтэй “тогтвортой” харилцаатай байна. БНХАУ болон АНУ-ын цэргийн харилцаа “тогтвортой” хөгжиж байна. Хоёр орны хувьд “харилцан итгэлцэл хүндэтгэлтэй, адил, тэгш байх” зарчим үндэслэн

15. <http://www.mod.gov.cn/reports/201102/>

эрүүл, тогтвортой цэргийн харилцааг хөгжүүлэхийг хичээж ирсэн. БНХАУ болон ОХУ-ын цэргийн харилцааны онцлогийг “байнгын дэвшилттэй” гэж тодорхойлж болох ба хоёр талын удирдлагуудын харилцаа, мэргэжлийн технологийн солилцоо, цэргийн нэгдсэн маневр, боловсон хүчний сургалтын талын хамтын ажиллагаа тасралтгүй гүнзгийрч байна.

2. Хил залгаа улс орнуудтай “сайн” харилцаатай. Хэдийгээр БНХАУ болон хил залгаа зарим орнуудын хувьд маргаантай асуудлууд байгаа ч гэсэн сүүлийн 10 жилийн байдлаар хил залгаа орнуудтай хийх цэргийн харилцаа бүх талаар сайн байна. Хил залгаа орнуудын зэвсэгт хүчинтэй харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бүс нутгийн энх тайвнаар тогтвортой байдлыг хамгаалахад чухал үүргийг гүйцэтгэж байна.

3. Хөгжиж буй орнуудтай цэргийн “бодит” харилцаатай. БНХАУ болон хөгжиж буй орнуудын зэвсэгт хүчний удирдлагууд харилцан айлчлал хийж, цэргийн дасгал сургуулилт, боловсон хүчний сургалт, тоног төхөөрөмжийн тал дээр хамтран ажиллаж, цэргийн уламжлалт найрсаг харилцааг бэхжүүлэн хөгжүүлж байна.

4. Аюулгүй байдлын талаарх хэлэлцээ, хамтын ажиллагааны тал дээр “амьд” хэмээн тодорхойлж болно. БНХАУ Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын батлан хамгаалах, аюулгүй байдлын хамтын ажиллагааг дэмжиж, АСЕАН-ны орнуудын бүс нутгийн чуулган болон батлан хамгаалах яамны сайдуудын зөвлөгөөн зэрэг цэргийн хэлэлцээр, хурал чуулганд идэвхитэй оролцож, стратегийн орон зайгаа өргөжүүлж байна гэж дүгнэжээ.

2. БНХАУ-ын зэвсэгт хүчний энхийг хамгаалах үйл жиллагаанд оруулж буй хувь нэмэр

1990 онд БНХАУ анх удаа энхийг хамгаалах үйл хэрэгт оролцож, 1992 онд анх удаа стратегийн бус цэргийн ангийг зохион байгуулж энхийг хамгаалах үйл хэрэгт оролцуулахаар илгээсэн.¹⁶ 1997 оны 5 сард Хятадын засгийн газар зарчмын хувьд НҮБ-ын энхийг хамгаалах үйл ажиллагааны бэлтгэл арга хэмжээнд оролцохоор шийдвэрлэж, цэргийн ажиглагч, иргэний цагдаа, материал хангамж, инженерийн анги зэргийг илгээхээр бэлтгэжээ. 2002 оны 2 сард БНХАУ нь албан ёсоор НҮБ-ын нэгдүгээр зэргийн энхийг хамгаалах бэлтгэл арга хэмжээний механизмд нэгдэн орж, мөн түүнчлэн НҮБ-ын стандартад нийцсэн инженерийн батальон, эмнэлгийн анги, энхийг хамгаалах бэлтгэл анги болгон тээвэр холбооны 2 ангийг байгуулсан. Энхийг хамгаалах үүрэг хүлээж авсанаас хойш 90 хоногийн дотор НҮБ-ын энхийг хамгаалах үйл ажиллагаа явуулж буй бүс нутагт илгээжээ. 2003 оны 4 дүгээр сард БНХАУ нь Конго руу инженерийн болон эмнэлгийн анги илгээсэн нь энхийг хамгаалах бэлтгэл арга хэмжээний механизмд нэгдэн орсны дараа анх удаа цэрэг дайны бус ангийг байгуулж энхийг сахиулах үйлст оролцож буй хэрэг юм.

16. www.mod.gov.cn

2000 онд БНХАУ-ын цагдаагийн алба анх удаа НҮБ-ын энхийг хамгаалах үйл ажиллагаанд оролцсон бол 2007 оноос БНХАУ нь энхийг сахиулах зорилгоор цагдаагийн ангийг илгээсэн нь анх удаа цэргийн шинжтэй хүчинг НҮБ-ын үйл хэрэгт оролцуулсан явдал болсон. Өнөөг хүртэл Азийн Зүүн Тимор, Афганистан, Европийн Босни Герцеговен, Косово болон Африкийн Либериа, Судан, Америк тивийн Гайти зэрэг 7 бүс руу энхийг сахиулах зорилгоор 1500 гаруй цагдаагийн мэргэжилтэнг илгээжээ. 2012 оны 9 сарын байдлаар 200 гаруй цагдаа НҮБ-ын энхийг хамгаалах 4 бүсэд үүрэг гүйцэтгэж байна гэж Хятадын батлан хамгаалах яамны гадаад хэргийн албаны дарга мэдэгджээ.¹⁷

2008 оны 11 сарын байдлаар НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагааны хэлтэс болон НҮБ-ын үйл ажиллагаа явуулж буй 9 бүс нутагт Хятадын 1949 энхийг сахиулах цэрэг дайчид үүрэг гүйцэтгэж байжээ. Үүнээс дурдвал Конго улс дахь НҮБ-ын үйл ажиллагаанд (UNMONUC) цэргийн ажиглагчид болон штабын офицерууд 88, инженер техникийн дайчид 175 мөн эмнэлгийн боловсон хүчин 43; Либер дэхь НҮБ-ын үйл ажиллагаанд (UNMIL) инженер техникийн албаны дайчид 275, тээвэрлэлт хариуцсан дайчид 240, эмнэлгийн боловсон хүчин 43; Судан дахь НҮБ-ын үйл ажиллагаанд (UNMIS) инженер техникийн албаны дайчид 275, тээвэрлэлт хариуцсан дайчид 100, эмнэлгийн боловсон хүчин 60; Ливан дахь НҮБ-ын түр хугацааны зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд (UNIFIL) инженер техникийн албаны дайчид 275, эмнэлгийн боловсон хүчин 60; Дарфур дахь Африкийн холбоо, НҮБ-ын үйл ажиллагаанд 315 инженер техникийн албаны дайчид тус тус оролцсон байна.

Өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд Хятадын 20000 гаруй дайчид болон цэргийн ажиглагчид НҮБ-ын энхийг сахиулах 20 гаруй үйлсэд оролцсон хэмээн 2012 оны 7 сард Хятадын батлан хамгаалах яамнаас мэдээлжээ. 2012 оны 7 сарын байдлаар Хятадын 2000 энхийг сахиулагчид 12 газар үүрэг гүйцэтгэж байна хэмээн НҮБ-ын цэргийн штабын хороо дахь Хятадын төлөөлөгчийн удирдагч, ерөнхий генерал Жан Жиангуо хэлсэн байна.¹⁸ Мөн тэрээр одоогийн байдлаар БНХАУ 150 гаруй оронтой цэргийн харилцааг хөгжүүлж, жил бүр 400 гаруй Хятад болон гадаадын төлөөлөгчид солилцон айлчилж байна хэмээжээ.

Энхийг хамгаалах үйл хэрэгт оролцох анги нь ихэвчлэн цэрэг дайны бус, харин барилга байгууламж, зам, гүүр, онгоцны буудал барьж засах, аюул ослоос аврах, бараа материал тээвэрлэх, эмнэлгийн тусламж, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зэрэг үйл хэрэгт оролцсоор иржээ. Сүүлийн жилүүдэд БНХАУ нь НҮБ-ын энхийг хамгаалах үйлст санхүүгийн тусламж үзүүлэх болсон байна. 2007 онд олон төрлийн үйл

17. http://www.mod.gov.cn/photo/2010-01/23/content_4119956.htm

18. www.mod.gov.cn

хэрэгт 270 сая ам.долларын хандив өгсөн нь 2006 оныхтой харьцуулахад 42 хувиар өсчээ. 2010 оноос хойш энэхүү тоо нь 400 сая ам.доллар болж өссөн байна.¹⁹

3. Хятадын зэвсэгт хүчний өнөөгийн хөгжлийн талаарх БНХАУ-ын болон бусад орны байр суурь

ХКН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Зиньтао намын 18-р их хуралд тавьсан илтгэлдээ «Улсын стратегийн хөгжлийн болон улсын аюулгүй байдалд тавигдаж байгаа шинэ шаардлагын дагуу армийн түүхэн үүргийг шинэ зуунд, шинэ шатанд бүрэн биелүүлэх шаардлага урган гарлаа. Цэрэг стратегийн бодлогыг шинээр батлан хамгаалах салбарт идэвхитэй хэрэгжүүлэн, төрөл бүрийн цэргийн ажиллагааны даалгаврыг биелүүлэх боломжуудыг нэмэгдүүлж, юуны түрүүнд мэдээллэлжүүлэлтийн нөхцөлд орон нутгийн чанартай мөргөлдөөнд ялалт байгуулах нь чухлаар тавигдаж байна» гэж дурджээ.²⁰ Мөн 2013 оны 1 сарын 31-нд Батлан хамгаалах яамны сайтад гарсан мэдээлэл дээр ХКН болон Цэргийн Төв Зөвлөлийн удирдлагууд хүчирхэг зэвсэгт хүчинг байгуулахаа онцлон тэмдэглэснийг мэдээлжээ.²¹

Хятадын цэргийн хүч чадал таамаглаж байснаас илүү хурдан өсч байна гэж америкийн шинжээчид үзжээ. Жил бүр цэргийн төсөв зардал нь нэмэгдэж тэр хэмжээгээрээ Ази Номхон далайд аюул учруулж болзошгүй улс бол БНХАУ хэмээн тэд үзэж байна. Пентагоны шинэ илтгэлд Хятадын зэвсэгт хүчний стратеги нь хэт орчин үеийн түвшинд, тухайлбал, сансар, кибер орон зайд тодорхойлогдож байгаа тухай дурьджээ. Мөн сүүлийн жилүүдэд БНХАУ цэргийн технологи, тоног төхөөрөмжөө шинэчлэснээ нотлон харуулсаар байна. Тухайлбал 2011 оны 7, 8 сард тив алгасан нисэгч пуужин, анхны хөлөг онгоц тээвэрлэгч Лиаонин усан онгоцны туршилт, мөн 2012 оны 11 сард анхны онгоц тээвэрлэгч хөлөг онгоц дээрээс байрласан J-15 анхны сөнөөгч онгоцыг хөөргөж, буулгах туршилтийг амжилттай хэрэгжүүлсэн байна. Мөн 2013 оны 1 сард анхны Хятадад үйлдвэрлэсэн тээвэрлэгч нисэх онгоц Y-20, мөн 2 сард Хятадын 2 дахь үл үзэгдэгч J-31 хэмээх сөнөөгч онгоцыг амжилттай туршжээ.²²

БНХАУ-ын цэргийн хүчний шинэчлэл нь америкийн цэргийн шинжээчдийн үзэж буйгаар АНУ-ын стратегийн сонирхолд заналхийлж байгаа аж. Оросын геополитик судлалын академийн шинжээч Константин Сивков АНУ-ын тэнгисийн цэргийн хүчний цэргийг өөрчлөн байрлуулах асуудлыг хөндөн мэдэгдэхдээ «Одоо чухам Ази Номхон далайн бүс нутагт анхаарлаа төвлөрүүлнэ гэж АНУ үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалдаа тодорхойлов. Учир нь энэ бүс нутаг дэлхийн эдийн засгийн төв болж байгааг харгалзан үзсэн байх. Энэ төв Атлантаас

19. http://www.mod.gov.cn/photo/2010-01/23/content_4119956.htm

20. http://mongolian.ruyr.ru/2012_11_09/94055430/

21. http://eng.chinamil.com.cn/news-channels/china-military-news/2013-01/31/content_5203297.htm

22. http://eng.chinamil.com.cn/news-channels/china-military-news/2013-01/31/content_5203297.htm

Номхон далайн бүс, Зүүн- хойд, Зүүн-Өмнөд Ази руу чиглэн шилжиж байна. Үнэн чанартаа АНУ-аас энэ бүс нутагт ихээхэн ач холбогдол өгч байна. Харин Хятадын цэргийн сүр хүч зузаарч байгаа нөхцөлд нөлөөгөө хэвээр хадгалахад хэцүү»²³ гэв.

АНУ Хятадын нөлөөг хязгаарлах болон бүс нутгийн өөр гүрэн улсуудыг өөрийн талд татах зорилгоор «Азид буцаж» байна. Эдгээр улс АНУ-аас Ирак, Афганистан улсуудад цэргийн ажиллагаа явуулж байтал хөгжлийн шинэ загварыг АНУ-ыг оролцуулалгүй бүтээх асуудал дээр ажиллаж байлаа. Эдүгээ Вашингтонаас Хятад улсыг дээдлэж байгаад анхаарал тавьж, бүс нутагт аюулгүй байдлын батлан даагч гэгчийн статусаа бэхжүүлэхийг хичээх бололтой. Хятад энэ бүхнийг харгалзаж, байлдааны бэлэн байдлаа бэхжүүлж, «эдийн засгийн давшилт» хийж байна. Вашингтон америкийн эдийн засаг хүнд байдалд орсон нөхцөлд Ази Номхон Далайн бүс нутгийн орнуудын сонирхлыг татмаар худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны төслүүдийг санаачилж чадахгүй бололтой. Харин Бээжин энэ талаар нэлээд өргөн боломжтой байна.

Хятад улс бүс нутгийн хөршүүдтэйгээ байнга газар нутгийн маргаантай байдгийг АНУ тооцон үзэж байгаа нь тодорхой. Бүс нутаг дахь Хятад улсын тэргүүлэх үүргийг сулруулахын тулд Өмнөд Хятадын тэнгис дэх арлуудад өнгөлзөж байгаа орнуудыг дипломат шугамаар дэмжих ажиллагаагаа АНУ нэмэгдүүлж байна. Энэ будилаанд зуучийн үүрэг гүйцэтгэхийг ч санаархаж байгаа билээ хэмээн Оросын дуу хоолой мэдээлж байна.²⁴ Геополитикийн сөргөлдөөний төв Ази Номхон Далайн бүс нутаг руу эргэн шилжиж байна. Учир нь энэ бүс нутгийг АНУ, Хятад хоёр амин чухал эрх ашгийнхаа бүс хэмээн үзэж байна гэж ОХУ-ын Нийгэм-улс төрийн судлалын төвийн захирал Владимир Евсеев хэлээд “Эдүгээ Хятадыг тогтоон барих олон улсын системийг байгуулж байна. АНУ-ын тэнгисийн цэргийн ба цэргийн нисэх хүчний хүчирхэг баазыг Австралид байрлуулж байгаа нь үүнтэй холбоотой юм. Америкийн цэргийн байр суурийг Филиппинд ч бэхжүүлэх бололтой. Хятадад дөтлөх зорилгоор АНУ бүхнийг хийж байна. Энэ зорилгоор бусад улсад цэргээ нэмэгдүүлж мэднэ” хэмээжээ.²⁵

Энэ бүс нутагт АНУ нөлөөгөө нэмэгдүүлж байгаад Хятадын цэргийнхэн анхаарлаа хандуулсан нь мэдээж. Үүнийг ажиглахгүй байхын ч арга алга. Австрали улсад 2016 онд америкийн 2500 тэнгисийн явган цэрэг болон алсын нислэгийн нисэх хүчин байрлуулж, боомтын дэд бүтцийг барина. Япон улсад байгаа 50 мянган хүнтэй америкийн цэргийн хүчин болон Өмнөд Солонгост байгаа 28 мянган хүнтэй зэвсэгт хүчин дээр Австрали улсын цэргийн хүчин нэмэгдэх болно.²⁶

23. http://mongolian.ru/r.ru/2012_06_05/77104391/

24. http://mongolian.ru/r.ru/2012_03_05/67588979/

25. http://mongolian.ru/r.ru/2012_11_27/96043420/

26. http://mongolian.ru/r.ru/2012_03_05/67588979/

Одоо АНУ Номхон далай болон Энэтхэгийн далайд нисэх онгоц тээгч хөлөг онгоцны наанадаж хоёр бүлэгтэй байна. Мөн Өмнөд Солонгос, Япон, Филиппин, Австралитай хамтран явуулах тэнгисийн цэргийн хүчний сургуулилтанд үргэлж оролцож байна.

Азид америкийн цэргийн сүр хүчийг зузаатгаж байгаа асуудал БНХАУ-ын дарга Си Жин Пиний АНУ-д айлчилсан үеэрээ хийсэн хэлэлцээний нэгэн сэдэв болжээ. Энэ оны эхээр өрөнхийлөгч Барак Обамагийн зарлан мэдээлсэн цэргийн шинэ стратегийн дагуу АНУ цэргийн хүчээ Ази Номхон далайн бүс нутагт төвлөрүүлнэ. Ази Номхон далайн бүс нутагт цэргээ нэмэгдүүлэх гэсэн АНУ-ын төлөвлөгөөг БНХАУ дэмжихгүй байна гэж Си Жин Пин «Вашингтон пост» сонинд ярилцлага өгөхдөө мэдэгджээ.

Хятад улс ямар учраас цэргийн зардлаа нэмэгдүүлж, Хятадын ардын чөлөөлөх армийг шинэчлэж байгаагаа тайлбарлав. БНХАУ-ын үндэсний батлан хамгаалалтад зориулсан Цагаан номонд улс орныхоо ба Зүүн Азийн бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхийн тулд батлан хамгаалах чадвараа нэмэгдүүлж байна гэж онцлон тэмдэглэжээ. Батлан хамгаалах бодлогыг тусгах Цагаан номыг уламжлал ёсоор бэлтгэснээрээ Хятадын засгийн газар зэвсэгт хүчнийх нь хөгжил ил тод байгааг илэрхийлдэг гэж үздэг. Бээжин дэлхийн ба бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар хандлагаа тодорхойлохдоо эл асуудлаар бусад улстай яриа хэлэлцээ хийхэд бэлэн, яриа хэлэлцээ болон итгэлцлийн арга хэмжээг бэхжүүлэх нь өнөөгийн нөхцөлд зайлшгүй чухал гэж үзэж байна.

Хятадын хил орчмын байдал 2010 онд тогтворгүй байсан. Вашингтон байдал хүндэрснийг шалтаглан Өмнөд Солонгос, Японтой цэргийн хэлхээ холбоогоо идэвхтэй бэхжүүлэх болсон нь Бээжинд сэжиг төрүүлжээ. Тайваний хоёр эргийн харилцаа зөөлөрсөн ч Америк-Тайванийн цэргийн хамтын ажиллагаа БНХАУ-ын засгийн газрыг түгшүүлсээр байна. Бүс нутгийн тогтвортой байдалд ер бусын аюул ч тулгарсан. Тухайлбал Хятад ус хэрэглэх асуудлаар хөрш орнуудтай маргалдаж байна. Бүс нутагт тулгарсан сөргөлдөж болзошгүй аюул Хятад ба өөр улсуудыг цэргийн зардлаа нэмэгдүүлэхэд хүргэж байна. 2013 онд БНХАУ-ын цэргийн зардал 10 гаруй хувиар ахин өсөн нэмэгдлээ.²⁷ Бүс нутгийн өөр бусад улсууд үүнд анхаарал тавьж байна гэж аюулгүй байдлын талаархи шинжээч, Цэргийн шинжлэх ухааны академийн профессор Вадим Козюлин тэмдэглээд «Хятад шиг улс орны цэргийн машины хүч чадлыг зузаатгах явдал нь хөрш орнуудыг түгшүүлж байна. Зүүн-Өмнөд Азийн зарим орнууд зэвсэглэлээр хөөцөлдөж байна гэж үзэж байна. Томоохон хөрш улсын цэргийн хүч нэмэгдэж байгааг харсан Вьетнам, Япон, Энэтхэг, Тайланд, Индонези, Малайз, Австрали гээд олон орон өөрсдийгөө зэвсэглэж байна. Хятад «Цагаан номондоо» цэргийн төлөвлөгөөгөө даруухан тайлбарласан нь мэдээж юм. Зэвсгээ дан батлан хамгаалах зорилгоор л хэрэглэнэ гэж өөр

27. <http://blogs.wsj.com/chinarealtime/2013/03/05/chinas-military-budget-bump-what-it-means/>

ямар ч улсын нэгэн адил мэдэгджээ. Гэвч Орос улс Хятадын цэргийн сүр хүч эрс нэмэгдэж байгааг сэтгэл түгшин ажиглаж, цэргийнхэн мөн бусад хүчин зүйлийг арга буюу харгалзан үзэж байна» гэв.

Хятадын хөрш орнуудын байр суурь

Хятад улс бусад тусгаар ямар ч улсын адил батлан хамгаалах чадварынхаа асуудлыг биеэ дааж шийдвэрлэх эрхтэй. Бээжингийн сэргэн мандалтыг дэлхийн ба бүс нутгийн энх амгалан байдалд учирч болзошгүй аюултай холбож үзэх нь зүй бус хэрэг юм. Хятад улс цэргийн нэг ч эвсэлд нэгдэх гээгүй. Гэвч Хятад улс нээлттэй байж, сайхан сэтгэл гаргахаа үргэлж онцлож байгаа боловч Хятадын зэвсэгт хүчний сүр хүч эрс нэмэгдэж байгааг бүс нутгийн хөрш орнууд нэг утгаар тайлбарлаж байна. Цэргийн хөтөлбөрөө өргөжүүлэх замаар л болзошгүй аюулаас өөрсдийгөө хамгаалж болно гэж Хятадын хөршүүд үзэж байна. Орос улсын аюулгүй байдлын тулгамдсан асуудлын шинжээч, холбооны аюулгүй байдлын захирал асан армийн генерал Николай Ковалёв үүнтэй санал нэгтэй байна. Тэрээр Пентагоныг дэмжээгүй гэхдээ, Хятад улс цэргийн шинэ хүч чадалтай болох нь бүс нутагт тогтворгүй байдлыг бий болгоно гэж үзжээ. «Сүүлийн хэдэн жилд үнэхээр Хятадын цэргийн хүч чадал хэд дахин өссөн. Үүнд тус улс дэс дараатай авсан бодлогын дүнд хүрсэн юм. Энэ салбарт тэд хөрөнгө санхүүг хайрладаггүй. Хятад улс дэлхий дахинаар нэг ширхэг хийгдсэн бүх цэргийн техникийн загварыг түүн авдаг, дараа нь үйлдвэрүүддээ олноор үйлдвэрлэдэг. Гэхдээ би америкчуудын тэнцвэр алдагдана гэдэгтэй санал нийлэхгүй байна. Харин Хятад улс өнөөдөр дэлхийн хамтын нийгэмлэгтэй хангалттай тодорхой хэлээр ярьж байгаа. Миний бодоход хазайсан юм энд байхгүй л болов уу» гэж Николай Ковалёв хэллээ.

Эндээс дүгнэхэд Хятад улсын хувьд батлан хамгаалахын салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн зэвсэгт хүчний шинэчлэлийг эрчимжүүлж, зэвсэг, техникийн үйлдвэрлэлд орчин үеийн технологийг ашиглах болж, орчин үеийн зэвсэгт хүчний хөгжилтэй хөл нийлүүлэн алхахыг зорьж байна. Өөрийнхөө байр суурь, эрх ашгийг ямар ч үед хамгаалах хүчирхэг зэвсэгт хүчин урд хөршид бүрэлдэн бий болж байна.

Ашигласан номзүй

1. <http://www.mod.gov.cn>
2. <http://www.mod.gov.cn/reports/201102/>
3. <http://www.globalsecurity.org/military/world/china/budget-future.htm>
4. <http://inssblog.wordpress.com/2012/03/26/chinas-2012-defense-budget-get-steady-as-she-goes/>
5. http://mongolian.ruyr.ru/2012_03_04/67457737
6. http://www.chinadaily.com.cn/cndy/2012-04/09/content_15000905.htm
7. http://www.mod.gov.cn/photo/2010-01/23/content_4119956.htm
8. http://mongolian.ruyr.ru/2012_11_09/94055430/
9. http://eng.chinamil.com.cn/news-channels/china-military-news/2013-01/31/content_5203297.htm
10. http://mongolian.ruyr.ru/2012_06_05/77104391/
11. http://mongolian.ruyr.ru/2012_03_05/67588979/
12. http://mongolian.ruyr.ru/2012_11_27/96043420/
13. http://mongolian.ruyr.ru/2012_03_05/67588979/